



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 1/17

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбар дахь гадаадын зээл, тусламжийг зохицуулах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 18⁴ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2-ыг тус тус үндэслэн, Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн үзэл баримтлал-2030-тай уялдуулж, төсөл, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг Эрүүл мэндийн сайдад хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 383 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ



2017 оны 04 сарын 12 ны өдрийн
4/17 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Нарийн бичгийн
дарга: Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын
газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн
Гадаадын зээл тусламжийн бодлого зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга
 - Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын
дарга
 - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын
дарга
 - Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн
газрын дарга
 - Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн
газрын дарга
 - Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга
 - Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын
Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
 - Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын
газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/

НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Дэлхийн банкны Суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

ДОХ, Сүрьеэ, Хумхаа өвчинтэй тэмцэх Глобаль сангийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Япон Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (ЖАЙКА)-ийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (КОЙКА)-ийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Бүгд Найрамдах Турк Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (ТИКА)-ийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Люксембургийн Их Гүнт Улсын Гадаад хэргийн яамны төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Дэлхийн Зөн Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Үндэсний оношлогоо, эмчилгээний төв байгуулах төслийн зохицуулагч /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр IV, V
төслүүдийн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн
зохицуулагч /зөвшилцсөнөөр/

Цахим эрүүл мэнд төслийн зохицуулагч
/зөвшилцсөнөөр/

Зүрх судасны төв, Эх нярайн эрүүл мэнд ба Цахим
эрүүл мэндийн өргөжилт MON/005 төслийн
зохицуулагч /зөвшилцсөнөөр/

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн
төслийн зохицуулагч /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 14 ны өдрийн
А/М дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Эрүүл мэндийн салбар дахь гадаадын зээл, тусламжийг зохицуулах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үндсэн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт

- 2.1 Зөвлөл нь эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг зохицуулах, хоёр болон олон талт хамтын ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг бодлогын зөвлөмжөөр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллана.
- 2.2 Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 2.3 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хурал байна.
- 2.4 Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга удирдана. Зөвлөлийн даргын эзгүйд түүний эрх олгосноор Зөвлөлийн гишүүн удирдана.
- 2.5 Зөвлөл нь хагас жил тутам хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Зөвлөлийн хурлыг гишүүдийн олонх буюу 60 (жар)-аас дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд аливаа асуудлыг хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.6 Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй бол Зөвлөлийн нарийн бичгийн даргад мэдэгдсэний үндсэн дээр төлөөлөл томилон оролцуулах, эсхүл хуралдаанаас өмнө саналаа бичгээр өгсөн тохиолдолд хурлын ирцэд оруулан тооцно.

- 2.7 Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг жилээр гаргана. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн эхний улиралд багтаан Зөвлөлийн хурлаар батална.
- 2.8 Зөвлөлийн гишүүд Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, өөрийн хариуцаж байгаа төсөл, хөтөлбөр, албаны чиг үүргийн дагуу шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана.
- 2.9 Зөвлөл нь эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй бүх төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайланг авч хэлэлцэн тэдгээрийг салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулна.
- 2.10 Зөвлөл нь дараах чиглэлүүдээр техникийн ажлын хэсгийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан ажиллаж болох ба ажлын хэсгүүдийг Эрүүл мэндийн яамны харьяалах газар, хэлтсийн дарга нар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. Үүнд:
- 2.10.1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр – Нийгмийн эрүүл мэндийн газар
 - 2.10.2 Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр – Эмнэлгийн тусламжийн газар
 - 2.10.3 Эрүүл мэндийн салбарын бодлого, санхүүжилт, засаглал, төр хувийн хэвшлийн түншлэл, цахим эрүүл мэндийг хөгжүүлэх чиглэлээр – Бодлого төлөвлөлтийн газар
 - 2.10.4 Эрүүл мэндийн байгууллагын чадавхи, хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлээр – Төрийн захиргааны удирдлагын газар
 - 2.10.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр - Эмнэлгийн тусламжийн газар
 - 2.10.6 Эмийн аюулгүй байдал, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, зохицуулалтын бодлого, эрүүл мэндийн технологи, үйлдвэрлэлийн чиглэлээр – Эм, үйлдвэрлэл, технологийн газар
- 2.11 Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг Эрүүл мэндийн яамны харьяалах газар, хэлтсийн дарга холбогдох бусад хүмүүсийн хамт бэлтгэж, Зөвлөлийн даргад хурал болохоос ажлын 5 /тав/, Зөвлөлийн гишүүдэд 3 /гурав/-аас доошгүй хоногийн өмнө танилцуулна.